

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мандал сум дахь Сум дундын прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/237-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Мөнхзул Утас: 7036-2442 Цахим хаяг: munkhzult@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16-17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕПГ	Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**МАНДАЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ
ЗӨВЛӨХ Н.ГАНБААТАР ТАНАА**

2023.02.13 № СЭА-2023/237-НА-СТА-ТШЗ

таний _____-ны N _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар 558,157.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 88.2 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 11.8 хувиар хэмнэсэн байна. Тус байгууллага нь тайлант онд орон тоо дутуу ажилласнаар цалин, НДШ-ийн зардлыг 51,873.5 мянган төгрөгөөр хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 85.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байна.

СЭА-2023/237-НА-СТА-ТШЗ

018020921

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар нь МУЕП-ын 2022 оны А/101 дүгээр тушаалаар 29,422.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан ба батлагдсан төсвийн хүрээнд 18,545.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч бүртгэл, тайланд тайлагнасан байна.

МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 12,657.0 мянган төгрөгийг МУЕПГ-ын “Ахмадын сан-гийн дансанд шилжүүлж, төсөвт тусгагдаагүй зардал гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Handwritten notes and stamps in the top right corner, including the word "Төгрөгөөр" (in Mongolian) and some illegible signatures or initials.

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,026,300.00	9,189,250.00
34	УРЬДЧИЛГАА	6,700,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	6,700,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	8,326,300.00	9,189,250.00
35400	Хангамжийн материал	8,326,300.00	9,189,250.00
35410	Бичиг хэргийн материал	297,600.00	123,300.00
35420	Аж ахуйн материал	3,663,700.00	5,410,950.00
35440	Түлш, шатах тослох материал	140,000.00	180,000.00
35450	Барилгын засварын материал	4,225,000.00	3,475,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	415,214,763.61	440,008,183.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	415,214,763.61	440,008,183.76
39200	Биет хөрөнгө	409,864,363.61	434,657,783.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	292,727,765.56	292,727,765.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,023,994.40	-18,902,790.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,224,333.52	86,224,333.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,529,333.43	-49,909,333.39
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	91,696,512.88	129,863,562.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,411,272.98	-27,694,217.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,793,669.08	34,593,769.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,685,316.62	-12,317,306.16
39217	Ном	72,000.00	72,000.00
39300	Биет бус хөрөнгө	5,350,400.00	5,350,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,350,400.00	5,350,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	430,241,063.61	449,197,433.76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	430,241,063.61	449,197,433.76
51	Засгийн газрын хувь оролцоо	430,241,063.61	449,197,433.76
51100	Засгийн газрын оруулсан капитал	77,262,737.75	77,262,737.75
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	77,262,737.75	77,262,737.75
51200	Хуримтлагдсан үр дүн	153,406,163.42	172,362,533.57
51210	Өмнөх үеийн үр дүн	96,624,712.34	153,406,163.42
51220	Тайлант үеийн үр дүн	56,781,451.08	18,956,370.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	199,572,162.44	199,572,162.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	430,241,063.61	49,197,433.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	550,318,288.00	587,579,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,526,988.00	29,422,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,526,988.00	29,422,050.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,547,988.00	29,422,050.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,979,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	504,791,300.00	558,157,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,791,300.00	558,157,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,791,300.00	558,157,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	493,536,836.92	559,289,539.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493,536,836.92	559,289,539.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,205,723.63	491,988,844.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,693,394.71	377,551,063.06
210101	Үндсэн цалин	218,328,792.06	205,214,107.77
210102	Нэмэгдэл	115,260,602.65	147,973,902.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,104,000.00	19,265,000.00
210104	Урамшуулал	-	5,098,052.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,768,200.00	45,219,070.69
210201	Тэтгэврийн даатгал	29,086,300.00	31,677,777.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,170,500.00	3,180,263.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,536,400.00	2,371,639.66
210204	Ажилгүйдлийн даатгал	634,100.00	609,662.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,340,900.00	7,379,727.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,819,054.00	12,828,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,108,946.00	2,185,175.00
210302	Түлш, халаалт	8,741,916.00	8,741,815.00
210303	Цэвэр, бохир ус	1,968,192.00	1,901,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,363,700.00	19,322,152.00
210401	Бичиг хэрэг	8,272,783.00	6,086,150.00
210402	Тээвэр, шатахуун	8,620,000.00	7,765,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	636,266.00	2,053,652.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	607,400.00	368,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,227,251.00	3,049,250.00
2105	Нормативт зардал	-	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,130,494.00	5,389,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,978,600.00	320,000.00
210604	Урсгал засвар	19,151,894.00	5,069,100.00

2107	Томилолт, зочны зардал	1,315,000.00	3,900,000.00
210702	Дотоод албан томилолт	1,315,000.00	3,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,932,444.00	963,969.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,301,000.00	750,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	897,175.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,689.00	163,789.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	522,500.00	-
210807	Газрын төлбөр	6,080.00	6,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,183,436.92	25,315,389.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,882,000.00	1,590,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,232,800.00	9,885,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,068,636.92	13,840,389.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,331,113.29	67,300,695.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,331,113.29	65,540,695.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,331,113.29	65,540,695.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	56,781,451.08	28,289,610.15
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,333,240.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	9,333,240.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	56,781,451.08	18,956,370.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	504,791,300.00	558,157,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	504,791,300.00	558,157,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	504,791,300.00	558,157,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	504,791,300.00	558,157,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	484,861,400.00	539,612,100.00
299990	Устгал	0	0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	484,861,400.00	539,612,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,530,286.71	472,311,404.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,693,394.71	377,551,063.06
210101	Үндсэн цалин	218,328,792.06	205,214,107.77
210102	Нэмэгдэл	115,260,602.65	147,973,902.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,104,000.00	19,265,000.00
210104	Урамшуулал	0	5,098,052.80

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,768,200.00	45,219,870.69
210201	Тэтгэврийн даатгал	29,086,300.00	31,677,777.22
210202	Тэтгэмжийн даатгал	3,170,500.00	3,180,263.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,536,400.00	2,371,639.66
210204	Ажилгүйдлийн даатгал	634,100.00	609,662.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,340,900.00	7,379,727.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,819,054.00	12,828,100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,108,946.00	2,185,175.00
210302	Түлш, халаалт	8,741,916.00	8,741,815.00
210303	Цэвэр, бохир ус	1,968,192.00	1,901,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,684,200.00	17,344,002.00
210401	Бичиг хэрэг	8,305,283.00	5,906,850.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	6,015,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	636,266.00	2,053,652.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	684,600.00	368,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,558,051.00	3,000,400.00
2105	Нормативт зардал	-	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,517,994.00	5,474,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,270,100.00	1,155,000.00
210602	Тавилга	3,300,000.00	-
210604	Урсгал засвар	19,947,894.00	4,319,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,315,000.00	3,900,000.00
210702	Дотоод албан томилолт	1,315,000.00	3,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,441,444.00	2,758,969.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,810,000.00	2,545,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	897,175.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,689.00	163,789.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	522,500.00	-
210807	Газрын төлбөр	6,080.00	6,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,291,000.00	5,736,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	2,423,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,291,000.00	3,312,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,331,113.29	67,300,695.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,760,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,331,113.29	65,540,695.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,331,113.29	65,540,695.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,929,900.00	18,545,000.00

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,929,900.00	18,545,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,929,900.00	18,545,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,929,900.00	18,545,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,929,900.00	18,545,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,929,900.00	-18,545,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

К о д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	96,624,712.34	373,459,612.53
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	96,624,712.34	373,459,612.53
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	56,781,451.08	56,781,451.08
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	153,406,163.42	430,241,063.61
11	2022 оны 1-р сарын 1- нээрх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	153,406,163.42	430,241,063.61
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	153,406,163.42	430,241,063.61
19	Тайлант үеийн үр дүн	-	-	18,956,370.15	18,956,370.15
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	77,262,737.75	199,572,162.44	172,362,533.57	449,197,433.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4317143903
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэл	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	558,157,100.00	492,616,404.75	65,540,695.25	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,157,100.00	492,616,404.75	65,540,695.25	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,397,100.00	490,856,404.75	65,540,695.25	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,905,400.00	377,551,063.06	44,354,336.94	89.0
210101	Үндсэн цалин	237,261,200.00	205,214,107.77	32,047,092.23	86.0
210102	Нэмэгдэл	161,960,200.00	147,973,902.49	13,986,297.51	91.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,684,000.00	19,265,000.00	3,419,000.00	85.0
210104	Урамшуулал	0	5,098,052.80	-5,098,052.80	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,738,200.00	45,219,070.69	7,519,129.31	86.0
210201	Тэтгэврийн даатгал	37,221,800.00	31,677,777.22	5,544,022.78	85.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,879,100.00	3,180,263.55	698,836.45	82.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,103,300.00	2,371,639.66	731,660.34	76.0
210204	Ажилгүйдлийн даатгал	775,800.00	609,662.93	166,137.07	79.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,758,200.00	7,379,727.33	378,472.67	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,828,100.00	12,828,100.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,171,200.00	2,185,175.00	-13,975.00	101.0
210302	Түлш, халаалт	8,743,000.00	8,741,815.00	1,185.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,913,900.00	1,901,110.00	12,790.00	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,344,300.00	17,344,002.00	298.00	100.0
210401	Бичиг хэрэг	5,724,400.00	5,906,850.00	-182,450.00	103.0
210402	Тээвэр, шатахуун	6,016,000.00	6,015,000.00	1,000.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,081,600.00	2,053,652.00	27,948.00	99.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	634,300.00	368,100.00	266,200.00	58.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,888,000.00	3,000,400.00	-112,400.00	104.0
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,323,000.00	24,019,100.00	303,900.00	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,900,000.00	100,000.00	99.0
210602	Тавилга	10,000,000.00	9,800,000.00	200,000.00	98.0
210604	Урсгал засвар	4,323,000.00	4,319,100.00	3,900.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,900,000.00	3,900,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	3,900,000.00	3,900,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,543,600.00	2,758,969.00	3,784,631.00	42.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,328,500.00	2,545,100.00	3,783,400.00	40.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,000.00	163,789.00	1,211.00	99.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	6,100.00	6,080.00	20.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,314,500.00	5,736,100.00	9,578,400.00	37.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,423,500.00	2,423,500.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,891,000.00	3,312,600.00	9,578,400.00	26.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,760,000.00	1,760,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,760,000.00	1,760,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,760,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	558,157,100.00	492,616,404.75	65,540,695.25	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	558,157,100.00	492,616,404.75	65,540,695.25	88.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	558,157,100.00	492,616,404.75	65,540,695.25	88.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газар нь "Хууль тогтоох байгууллагын бодлогын үзэл санааг тууштай дэмжиж, хяналтын ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх, зон олны эрх, эрх чөлөө, эд баялаг, түүхт уламжлалыг сахин хамгаалж, хууль тогтоомжийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлэх" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх,
- Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах,
- Прокурорын ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх,
- Чадварлаг прокурор, ажилтныг сайшаан дэмжих,
- Прокурор, ажилтны суралцах орчин, нөхцөлийг бүрдүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.


Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын санхүүгийн үйл ажиллагаанд УЕПГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсээс хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Сум дундын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

УЕПГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/125 дүгээр тушаалаар УЕПГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,956.4 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Урьдчилж гарсан зардал	6,700.0	-	(6,700.0)
Бараа материал	8,326.3	9,189.2	862.9
Үндсэн хөрөнгө	415,214.7	440,008.2	24,793.5
Нийт хөрөнгө	430,241.0	449,197.4	18,956.4
Засгийн газрын хувь оролцоо	430,241.0	449,197.4	18,956.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	430,241.0	449,197.4	18,956.4

Өмнөх онд урьдчилж гарсан зардлаар тайлагнагдсан 6,700.0 мянган төгрөгийн гэрээт сургалтыг тайлант онд гүйцэтгэж гэрээг дүгнэснээр уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,189.2 мянган төгрөг болж 862.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,765.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 28,902.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 548,831.8 мянган төгрөг болж 37,967.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18,545.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, 29,422.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг МУЕП-ын 2022 оны А/101 тоот тушаалаар үнэ төлбөргүй хүлээн авсан болон МУЕП-ын 2022 оны А/79 дугаар тушаалаар 9,999.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил /архивын нягтруулсан шүүгээ/-ыг Баянгол дүүргийн Прокурорын газарт шилжүүлэн данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 449,197.4 мянган төгрөг болж 18,956.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт


Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 496,695.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 22,670.2 мянган төгрөгөөр бууруулж /хангамж, бараа материалын зардлыг 9,152.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,242.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,250.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,025.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан нь голлон нөлөөлсөн байна./ 474,025.0 мянган төгрөгөөр баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт цалин, нийгмийн даатгалд төлөх зардлыг 38,273.3 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 23,423.0 мянган төгрөгөөр гэх мэт нийт 84,132.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн санхүүжүүлэхээр 558,157.1 мянган төгрөгийн төсөв баталж санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс 558,157.1 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 492,616.4 мянган төгрөг буюу 88.0 хувьтай байгаа нь 2 орон тоо дутуу ажиллаж цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 51,873.4 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 9,578.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 3,784.6 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 303.8 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	553,897.1	488,356.4	65,540.7	88.0	
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,760.0	1,760.0	-	100.0	
3	Байцаан шийтгэх үйл ажиллагаа	2,500.0	2,500.0	-	100.0	
	Дүн	558,157.1	492,616.4	65,540.7	88.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130406401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 493,536.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,935.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор УЕПГ-ын 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 2/1579 тоот "Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай" албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Сургалт, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрт шилжүүлж холбогдон гарах зардлыг хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах.
- Худалдан авах бараа материалын төсвийг хийж, ерөнхий прокуророор хянуулан нэн шаардлагатай, зайлшгүй хэрэгцээт материалыг худалдаж авч зарцуулан, төсвийг зохистой удирдаж өр төлбөргүй тайлагнагдсан.



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Сум дундын Прокурорын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 1, таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 2, өмч хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийн 5 зэрэг нийт 8 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансанд мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулах мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, холбогдох баримтад хийсэн завсрын үеийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.


4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Тоо	Биелэлт	
	Тоо	Дүн		Дүн	Хувь
Зөвлөмж	4	35,112.4	4	35,112.4	100
Нийт дүн	4	35,112.4	4	35,112.4	100



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант жилийн төсөвт тусгагдаж, батлагдаагүй байхад МУЕП-ын 2022 оны А/118 дугаар тушаалын дагуу батлагдсан цалингийн зардлын 3.0 хувь болох 12,657.0 мянган төгрөгийг МУЕПГ-ын “Ахмадын сан-гийн дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,895.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Албан томилолтоор ажиллах удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 685.4 мянган төгрөгийн албан томилолтын зардал олгож, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажиллах удирдамж, гүйцэтгэсэн ажлын тайлан зэрэг анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2. Илрүүлэлт: Тайлант онд нийт 1,210.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана...” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн	1	685.4					1	685.4				
Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	1,210					1	1,210.0				
Дүн	2	1,895.4					1	1,895.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлээсэн	1						1	
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-					1	-